

# МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 14/393

НШУС

2013

### Д.ДАНЗАНРАВЖААГИЙН «СЭТГЭЛИЙГ АМРААГЧ» ХЭМЭЭХ СУРГААЛЫН ЗОХИОЛ НИЙТЛЭЛД ХОЛБОГДОХ НЬ

Н.Ариунзаяа\*

• «Отгонтэнгэр» их сургууль, Сэтгүүл зүйн тэнхимиин багш, доктор

**Түлхүүр уг:** сурвалж бичиг, нийтлэлийн утга зохиол, шашин, соёл, яруу найрагч, эрдэм мэдлэг, сэтгэлгээ, сургаал, ёс суртахуун, сургаалын түүвэр, мэргэн зөвлөгөө

**М**онголын оюун ухааны салбарын сор болсон үе үеийн мэргэд нийтлэлийн утга зохиолоос ангид байгаагүйг сурвалж бичгүүд хэлж өгдөг. Тэд тухайн үеийнхээ оюун санааг хошуучлагчид болохын хувьд оршин буй нийгмийнхээ бурангийг ёсыг эсэргүүцэн шүүмжлэхийн зэрэгцээ, гагцхүү гэгээрч соёлжсон олон нийтийг буй болгох замаар тэрхүү өө гажгийг засч болно гэж үздэг байжээ. Энэ үзэл нь тэднийг нийтлэлийн утга зохиол руу аяндаа татан оруулдаг байв. Учир нь нийтлэл бол утга зохиолын төрөл, зүйлүүд дотроос хүн ардад шууд хандаж, шуурхай нөлөөлдөг хамгийн дайчин хэлбэр юм.

Тийнхүү нийгмийн дээд ангийнхны ёс суртахууны доройтол, шударга бус байдал, шашин номынхны цалгайдал зэрэг зохисгүй үзэгдлийг илчлэн шүүмжилж, гэгээрэл боловсролыг тэдгээрийн эсрэг сөргүүлэн тавьж байсан шашин соёлын гарамгай зүтгэлтэн,

яруу найрагч, гүн ухаантан, шинэтгэгч үзэлтэн бол Говийн ноён хутагтын V дүр Дулдуйтын Данзанравжаа билээ.

1810 онд долоон настай байхдаа «Хурмаст тэнгэр» гэдэг дууг зохион дуулснаар авьяас билэг нь тодорч эхэлсэн тэрбээр амьдралынхаа туршид 1000 шахам гүр дуу, сургаалын шүлэг туурвисны дотроос монгол хэлээр бичсэн 170 гаруй, төвд хэлээр бичсэн 180 орчим бүтээл нь бидэнд баттай уламжилсан юм. Д.Данзанравжаа бас «Саран хөхөөний намтар», «Аварга могойн зулай дахь чандмань» гэх зэрэг жүжиг, хүүрнэлт зохиол бичжээ.

Түүний зохиолуудад нийгэм, улс төр, эрдэм мэдлэг, зан суртахууны сэдэв зонхилдог бөгөөд олонх бүтээлээ шүлгийн хэлбэрээр бичсэн байдаг. Тэрбээр өөрийн бүтээлээр нийгэмд шууд хандаж, аливаа дутагдлыг тойруулж товшуулалгүй, шударга үнэн бөгөөд хурц оновчтой үгээр илчлэн шүүмжилдэг барилаараа нийтлэлийн эрхэм зорилтыг хэрэгжүүлж чаддаг байлаа. Тийм зохиолуудын нэг нь «Сэтгэлийг амраагч» гэдэг сургаалын зохиол юм.

Д.Данзанравжаа эрдэм мэдлэг, эв найрамдал, зөвзргүү сэтгэл гурав бол

хүн төрөлхтний амар тайван амьдарч, хөгжиж дэвжихийн үр үндэс мөн гэсэн санааг энэ сургаал-нийтлэлдээ дэвшүүлэн тавьсан байна. Уг бүтээлд бас хүний жаргаж зовохын шалтгаан нь бурхан ч биш, ямар нэг далдын хүч, идшид ч биш, гагцхүү өөрийнх нь үйл үйлдлийн үр мөн гэсэн санааг гаргаж тавьсан юм. Энэ нь түүний шинэтгэгч үзэл санааны илрэл мөн. Тиймээс ч тэрбээр эрдэм мэдлэг, эв найр, зөв сэтгэл гурвыг сэтгэлийг амраагч “гурван эрдэнэ” хэмээн заасан байдаг. Тэрбээр бас шашин суртахууныг цэвэр ариунаар мандуулах замаар нийгмийн өө гажгийг залруулж болно гэж үзэж байлаа. Тэгэхдээ шашныг шинэтгэн ариутгасны үндсэн дээр түүнийг нийгмийн шударга бүх хүчнийг нэгтгэн нягтуулах хүч болгон хувиргахыг зорьж байв. Уг зорилтыг хэрэгжүүлэх арга зам нь нийгмийн бузар булаг бүхнийг үнэн үгийн хурц зэвсгээр илчлэн шүүмжилж, ноёлогч ангийнханд ёс суртахууны шилдэг сайн чанарыг зээмшүүлэх хэрэгтэй гэж үзэж байжээ. Энэ нь түүний зохиол бүтээлийг нийтлэлийн агуулгатай болгох чиглэл РҮҮ өөрийн эрхгүй түлхэж байсан юм.

«Сэтгэлийг амраагч» хэмээх сургаал-нийтлэлийн гурван тулгуур санааны нэг дэх нь эрдэм мэдлэгийг эрхэмлэн дээдлэх үзэл номлол юм. Эрдэм мэдлэгийн хүчээр бүхнийг ялан дийлж болно гэж тэр үздэг байв. Тиймээс эрдмийг аль болох багаасаа сурх, хичээнгүй бөгөөд тэвчээр тэсвэртэй сурх, өнгөц биш уг язгуураар нь ухаж сурх, сурсан эрдэмдээ эрдэж бардахыг цээрлэхийг эрхэмлэдэг байжээ. Тухайлбал: «Нарны гэрэл хурц болоход үүлгүй бол нэн сайн, насны багад эрдэм сурхад залхуугүй бол

даанч сайн», «Залуу нас өнгөрсөн хойно эрдэм сурхад бэрх» гэх мэтээр эрдмийг эрт сурхын чухлыг сургасан бол, «Номгүй хувраг гэзэггүйгээс бус юу вэ, номой зантай хүн хождохоос бус юу вэ» гэж эрдэмгүй атлаа эрдэмтний дүр эсгэх, огт эрдэмгүйгээсээ болж юм юмнаас хоцрохын аль алийг шүүмжилсэн байна. Түүнчилэн эрдмийг бага гэж гололгүй байнга сурхыг номлож «Балар шугуй модонд сармагчин дамжихад амархан, бага сага эрдэм нэмэр авахад хэрэгтэй», «Үзсэн эрдмээс мартагч хүн буянаар үгүйрэхийн тэмдэг, үлгэргүй эсгэсэн малгай эд эвдрэхийн шинж» гэх буюу «Бичиг эрдэм сурх хүнд хичээнгүй самбаа хэрэгтэй», «Муруй сумыг залбал бай онох нь шалав, мунхаг хүнийг тордвол мал хариулах нь хямгатай» гэхчилэн сургасан байдаг. Д.Данзанравжаа «Цагийн жамыг тодруулагч цаасан шувуу», «Бяцхан хөвгүүндээ зориулсан сургаал» болон бусад зохиолдоо ч эрдэм ном сурхын ач тусыг онцгойлон дурдсан байдаг. Тухайлбал: «Эдийн баялагт бүү эрд, эрдмийн баялгийг бүү цэнэ», «Өөрийн эрдмээр битгий омогш, нөхдийн эвийг эрхэмлэ», «Сүүлгүй тогос луугийн дуу сонсовч шүхэрлэхийн аргагүй, сүсэггүй шавьд үнэн үг хэлэвч авахын хувьгүй» гэх мэтээр сургасан байна.

**Д.** Данзанравжаагийн «Сэтгэлийг амраагч» сургаал-нийтлэлийн хоёр дахь тулгуур үзэл номлол нь эвийн хүчийг эрхэмлэх санаа юм. Тэрбээр Монголын үе үеийн суу билэгтнүүдийн нэгэн адил “эвтэй байхдаа хүчтэй” гэсэн сургаалыг номлогчдын нэгэн байжээ. Тэгэхдээ эв зе гэдэг ойлголтыг нийгмийн нэгж болсон бие хүмүүсийн харилцаанаас

Эхлээд улсыг засах ноёд түшмэд, төр гурнуудийн харилцааны хүрээнд авч үзэж байсан нь хэчинээн өргөн дэлгэр сэтгэлгээтэй хүн байсныг нь харуулдаг. Жишээ нь «Өнгөтэй боловч ясгүй магнаг харгана бутны тоглоом, өнөр боловч эвгүй улс өнчин хүний элэг доог», «Ихсийг эс хүндэлсэн хүн самоурахын шинж, эвийг эс бодсон ихэс хөнгөрөхийн шинж», «Хоёр түшмэл эвтэй бол хааныг ч болов чадах, хоёр хаан эвтэй болбол дайчин улс амгалан болох», «Мэргэн хүнд ч нөхөр хэрэгтэй, мунхаг хүнд ч түшиг хэрэгтэй», «Эв тангараг сайн бол хөгшин залуу хоёр ч ханилж болно», «Хүн сайн ч ганцаар бүгдийг яахин дийлэх вэ, тонгорог хурц ч чулууг яахин даах вэ» гэж эв зэйин хүчийг өгүүлсэн бол, «Цийдэм удахаараа гашилдаг, хүн удахаараа уйддаг», «Удахгүй эвээр юу хийх вэ, батгүй зангаар юугаа хийх вэ?», «Нойроо бэхлэхгүй хүн манаа битгий мана, эвээ чадахгүй хүн яарч битгий ханил», «Янаг болбол эвтэйхэн яв, өшөөтөн болбол дуугүй суу», «Хүчилснээс эвийг нь олбол хямд, хэрэлдсэнээс учраа хэлэлцвэл шулруун» гэх мэтээр эв найраа эрхэмлэхийн тулд яах ёстойг сургасан байдаг.

Д.Данзанравжаагийн «Сэтгэлийг амраагч» сургаал-нийтлэлийн гурав дахь гол санаа нь зеевзргүү зөв сэтгэлтэй байвал үйлс бүтэж, амьдралын баяр жаргалаар дүүрэн явах болно гэсэн үзэл юм. Бас хүний хүмүүжил, ёс суртахууны төлөвшлийг хангах замаар нийгэмд шинэчлэл хийж болно гэж үздэг байв. Данзанравжаа өөрийн аж төрж байсан үеийн нийгэм-улс төрийн хямралт байдлаас шалтгаалан нийт нийгмээрээ ёс суртахуунаар доройтоож, хүний мөс чанар муудсаныг зохиол

бүтээлдээ хурц оновчтой, үнэн үгээр илэрхийлэн гаргаж байсан нь өнөө цагт нэн сургамжтай юм. Тэрбээр нийгэм ёс суртахууны уналтад орж, шударга ёс орхигдоход хүрсэн нь ард олны гай зовлон, нийгмийн зөрчлийн үндэс болж байгааг илэрхийлж:

«Энэ цагийн алаглагч ноёд, идэгч түшмэд

Хариу бодогч өглөгийн эзэд  
Тэмцэлдэгч ардаас эхлэн  
Ертөнц ба номын зүг гэвч  
Суудлын төлөө олох нэр  
Эдийн төлөө номлох ном  
Алдрын төлөө үйлдэх буян  
Өмгийн төлөө шүтэх шавь тэргүүтэн  
Муу явдлыг өөрсдөө үйлдээд цагийн  
муу гэнэ» хэмээн бичжээ. Энэ нь тэрбээр нийгмийн хямрал задралын шалтгааныг хүний өөрийнх нь ёс суртахуунтай холбон үзэж байсны гэрч юм.

**Д.** Данзанравжаа «Сэтгэлийг амраагч» сургаал-нийтлэлдээ «Нохой ч бол сүүлтэй нь сайхан, гуранч ч бол ёстай нь сайхан», «Тугалган жад шантрах нь хурдан, туйлбаргүй хүн буцах нь олон», «Галыг унтраахад ус хэрэгтэй, өшөөг арилгахад тус хэрэгтэй», «Их хүнд даруулга байтугай бурханд ч ахмад бий, энгийн хүнд сургаал байтугай эзэнд ч ёс бий», «Баас шээс эс гарвал биенд өвчин болох, бага сага гомдлыг эс илчилбэл сэтгэлд зовлон болох», «Саруул тал байвч шаврыг нь мэд, сайхан янаг байвч санааг нь тань», «Үнэн үг хатуу ч хэтийн явдалд тустай», «Урт модыг огтлох хүнд хөрөө нөхөр болох, улс олонгой ханилах хүнд сээрэмж нөхөр болох», «Шувуу торноос алдагдвал барихад бэрх, шууд үг алдвал баллахад бэрх», «Авд сайн

нохой турхирах цагт хуцан давхих, ашид сэтгэл таарч ханилсан нөхөр асуух цагт урамтай», «Номхон явах ихэдвэл нохой мэт шоологдоно, догшин явах урьдвал хүний гарч ноцогдоно», «Хүн олон боловч үхэхээ мэдэх нь цөөн, ухаантан олон боловч хойтоо санах нь бэрх», «Бусад хүний гэмийг отож суухаа байгаасай, биеэ өмөөрөхийг урьдавч уг хэлэхдээ хождоосой», «Бугын эвэр урт ч модонд юу нь ороолдох вэ, буруу явдал олон ч өөрөө яаж мэдэх вэ» гэх мэтээр нийгмийн гишүүдийн харилцааны хэм хэмжээ, зан суртахууны эрхэм чанарыг тодорхойлсон байдаг.

Д.Данзанравжаа-гийн сургаал-нийтлэлийн хүмүүжлийн ач холбогдол зуунаас зуунд улам өсч, алт шиг өнгө орон гялалзаж байгаа билээ. Тэрбээр бурханы шашны улааны чиглэлийг баримталдаг байсан нь ертөнцийн амьдралд идэвхтэй хутгалдан орж, илүү чөлөөтэй сэтгэх боломжийг нээж өгсөн онцлог бий. Тиймээс ч түүний сургаалын зохиол, нийтлэлүүдийг эрдэмтэн судлаачид анхааран судлах цар хэмжээ өргөжиж байгаа юм.

Судлаач Г.Лхагвасүрэн «Данзанравжаа бол бурханы шашны яруу найргийг иргэншүүлэх чиглэлд томоохон алхмыг хийсэн авьяаслаг найрагч»<sup>1</sup> гэж дүгнэсэн нь түүний сургаалын шүлгүүд нийтлэлч шинжтэйг ямар нэг хэмжээгээр хүлээн зөвшөөрсөн хэрэг юм.

Түүнчилэн доктор, профессор Л.Норовсүрэн «Д.Данзанравжаагийн сургаалын шүлгүүд нь өө сэвээ барж, улам бүр цэнэгшсэн ардын цэцэн мэргэн үгс мэт агаад, хүнд ухаарал хайрлах гүнзгий санаатай, хурц тод өгүүлэмжтэй байдгаараа орчин үеийн нийтлэлд тавигддаг шаардлагад гойд нийцдэг билээ»<sup>2</sup> гэсэн нь түүний «Сэтгэлийг амраагч» хийгээд бусад бүтээлд нийтлэлийн зүйлс арвин байна гэсэн бодлыг минь итгэлтэй болгож байна.

«

*Д.Данзанравжаа өөрийн бүтээлээр нийгэмд шууд хандажс, аливаа дутагдлыг тойруулжс товшуулалгүй, шударга үнэн бөгөөд хурц оновчтой үзээр илчлэн шуумжилдэг барилаараа нийтлэлийн эрхэм зорилтыг хэрэгжүүлж чаддаг байлаа.*

»

амьдарч байсан хүн юм. Тэр зөрчилт байдал нь Данзанравжааг хурц дайчин үгтэй шүлэглэсэн шүүмжлэлт нийтлэл бичихэд өөрийн эрхгүй уриалан дуудсан гэж болно. Тэрбээр шашин бурхан хийгээд ариун шударга үйлсийг худал хурмагийн хар сүүдэр дайрч, нийгэм хөл толгойгоо олохoo байсанд харамсан,

«Ачит эх болсон амьтны зовлон Ахуй орчлонгийн нэн хуурамчhan байдал

Алдарт Мунийн шашны доройтол

Энэ гурвыг санаад голоосоо гашуудна» гэж «Аврал бүхэн хурсан» хэмээх зохиолдоо тэсч ядан бичсэн байдаг. Тэрбээр бас «Арга баширын цогц» гэдэг бүтээлдээ «Үзлийн муу өрнөсөн ийм хачин цагт үнэн үтэн омогтны тоонд орно, башир үтэн

цэний суудалд сууна. Үнэн шударга өгүүлэгч хүн цагаан хэрээ, үнэнч ариун явдалтан нь муушаалын орон, аяа маш уйтгартай ч орон юм даа» хэмээн бичиж байсан нь түүний шинэтгэгч үзлийн илрэл юм.

Д.Данзанравжаагийн үзэл бодол төлөвшиг орчин нөхцөл тухайн гол төлөв үе залгамжилсан тэр үеийн төр, шашны дээд ангийнхныхаас эрс өөр байсан нэг онцлог бий. Тэрбээр найман насандаа хутагтад өргөмжлөгдөх хуртлээ ядуу зүдүүгийн зовлонг амсаж өсөхдөө ихэс дээдсийн бардам дээрэнгүй зан, шударга бус байдлыг жигшиж, нийгмийн тэгш бус байдлын шалтгааныг эрж хайх сэтгэлгээнд хөтлөгдөх болсон нь ертөнцийг үзэх үзлд нь ихээхэн нөлөөлжээ. Түүний эцг Дулдуйт Шилийн голын чуулганы зүүн Сөнөд вангийн хошууны ядуу ард байсан бөгөөд амьдралын эрхээр гүйлаа гүйж явдаг нэгэн байсан гэдэг. Энэ тухайд академич Д.Цэрэнсодном бичихдээ «Данзанравжаагийн эцг нь Өлзийт буюу төвдөөр Даш гэдэг хүн байсан бөгөөд дулдуй барьж, олон түмнээс гүйлаа гүйн амь зогоож явсан учраас Дулдуйт гэдэг хотой болсон байх»<sup>3</sup> гэсэн таамаглал дэвшүүлсэн байна.

Данзанравжаа зарим шүлэг зохиолдоо «Өлзийтийн хүү өнөөх гайхал дуулав» гэж бичсэн нь дээрх таамаглал үнэн байх магадлалыг өсгөж байгаа юм. Хамгийн гол зүйл бол багасаас ядуу зүдүү амьдралыг биеэр туулж, хутагтаар өргөмжлөгдсөнийхөө дараа ч гэсэн эгэл ардын амьдралд ойр байж, тэдний баяр цэнгэл, зовлон бэрхшээлийг хуваалцаж явсан нь шинэтгэх үзлийнх нь хөрс суурь болсон гэж үзмээр байдаг.

«Сэтгэлийг амраагч» нь хэлбэрийн хувьд шүлэглэсэн, бүтцийн хувьд цэцэн мэргэн сургаалын түүвэр маягтай, агуулгын хувьд соён гэгээрүүлж, сурган хүмүүжүүлсэн шинжтэй бүтээл юм. Эдгээр гурван онцлогийн аль нь ч нийтлэл бүтээхэд хэрэглэгддэг элементүүд юм. Тиймээс «Д.Данзанравжаагийн бүтээлд өгүүлэх арга маяг, гадаад хэлбэрээрээ нийтлэл гэмээр зүйл ховор боловч зорилго, агуулгаараа оршин буй нийгмийнхээ араншинг сум шиг онож, шууд илчилсэн нийтлэл олон байдаг» гэсэн судлаачийн дүгнэлттэй санал нийлэхэд хүрдэг. Үнэхээр нийтлэлийн бүтээлийн мөн чанар нь түүний хэлбэр, өгүүлэх ур маяг биш, харин зорилго, агуулга хоёрт нь оршиж байдаг билээ.

**T** одруулбал нийтлэл нь уран зохиол шиг хүмүүжүүлэх зорилтоос илүү хүнд хэрэг болох, ажил амьдралд нь тус болох шинэ санаа, мэдлэг мэдээллийг шууд хүргэж байдаг. Д.Данзанравжаагийн зохиол дотор байгаа «Зөв бол бүхэнд дайсан болсон ч үйлд, буруу бол хааны суудалд суулгавч зайл», «Бэрхэд бүү цухалд, хялбарт бүү ташуур», «Бэлгэтэйг өмсөж здэл, зохистойг идэж уу», «Аж төрөхийн хэргийг арга зүйгээр гүйцэтгэ, алба ахуйн хэргийг алгуурлалгүй бүтээ», «Өөрийн тусыг урьд нь өг, нөхрийн тусыг ард нь ав», «Зарснаа мэдэж хэрэглэхээ жиш, хурааснаа үзэж хүрэлцэхээ зөвлө», «Хорлох сэтгэлийг хол болго, хоёрлох сэтгэлийг цэцнээр чим» гэх мэт сургаалууд нь хүний зан чанар, ажил хөдөлмөртөө баримталж явах мөрдлөг, мэргэн зөвлөгөө болж байгаагаараа нийтлэлийн үйл хэргийг биелүүлж байгаа юм.

Д.Данзанравжаа «Сэтгэлийг амраагч» хэмээх сургаал-нийтлэлийнхээ төгсгөлд «Муу хүү минь чамдаа ертөнцийн хар хүний ёсыг голдож өгүүлэв би»<sup>4</sup> гэснээс үзэхэд ч хэн хүний үйл хэрэгт мөрдлөг болох амьдрал ахуйн сургаал зөвлөгөө болгож бүтээлээ туурвисан нь тодорхой байна. Дээр дурдсан жишээ баримтад тулгуурлан «Сэтгэлийг амраагч» хэмээх сургаалыг нийтлэлийн бүтээл гэж үзэх хэдэн үндэслэлийг дурдвал:

**Н**эгд: Энэ бүтээл хүний амьдрал ахуйдаа мөрдөж явбал зохих чухал сургамжийг өгч байгаа; хоёрт: нийгэмд шууд хандаж үйл хэрэгт нь тус болох санаа агуулсан; гуравт: хүнийг хүмүүжүүлэх, гэгээрүүлэх үүргийг нэгэн зэрэг гүйцэтгэж байгаа зэрэг болно. Эцэст нь тэмдэглэхэд энэхүү сургаал-нийтлэл XIX зууны Монголын утга зохиолын үнэт дурсгал болохын зэрэгцээ өнөөдөр ч ач холбогдолтой хэвээрээ байна.

### Ишлэл

<sup>1</sup> Лхагвасүрэн Г. 2001. Ноён хутагт Данзанравжаа // «Монголын философиийн түүх» (XVIII-XIX зуун). IV дэвтэр. УБ., 331 дэх тал.

<sup>2</sup> Норовсүрэн Л. 2004. Монголын нийтлэл. I боть. УБ., 177 дахь тал.

<sup>3</sup> Цэрэнсодном Д. 1987. Монголын уран зохиол. УБ., 163 дахь тал.

<sup>4</sup> Мэргэд гарахын үүд. Цуврал №3. УБ., 33 дахь тал.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баатар Д. 1993. Тавдугаар догшин ноён хутагт Равжайн цэдэг. УБ.
2. Дамдинсүрэн Ц. 1999. Монголын уран зохиолын тойм. I боть. УБ.
3. Лхагвасүрэн Г. 2001. Ноён хутагт Данзанравжаа // «Монголын философиийн түүх» (XVIII-XIX зуун). IV дэвтэр. УБ.
4. Мэргэд гарахын үүд. Цуврал №3. УБ.
5. Норовсүрэн Л. 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. I боть. УБ.
6. Норовсүрэн Л. 2004. Монголын нийтлэл. I боть. УБ.
7. Хүрэлбаатар Л. Огторгуйн цагаан гарди. УБ.
8. Цэрэнсодном Д. 1987. Монголын уран зохиол. УБ.

### Summary

In this article I tried to prove that the teaching poem "The Pacifier of Mind" by Noyon Khutagt Danzanravjaa is indeed literary monument. The teaching poem is about three things: revering knowledge, treasuring collective strength and having positive and good spirit.